



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 9/113

Улаанбаатар хот

### Хоол, хүнсээр хангах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.2, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 286 дугаар тогтоол, 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох тухай журам”-ын 8.4, Онцгой байдлын өрөнхий газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/251 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өдрөөр ажилдаг төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлыг ажлын нэг өдөрт 4500, ээлжээр ажилладаг алба хаагчийг хоолоор хангах, хүнсний зардалд нэг өдөрт 8000 төгрөгөөр тооцон хүнс хангамжийн хоногийн нормоор ханган ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

2. Хоол, хүнсний зардлыг тогтоосон нормын дагуу хангалтыг зохион байгуулж ажиллахыг харьяа бүтцийн нэгжийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нөхөн төлбөр шинэчлэн гарсантай холбогдуулан дотоод журманд нэмэлт өөрчлөлт оруулахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА  
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

